



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2018.05.25, БААСАН ~ №106 (905)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Маршалд итгэгдсэн Н.Лхамсүрэнг шившиглэсэн түүх
Тэрхүү гайтай Бүгд хурлын дараа түүнийг үүрэгт ажлаас нь бүрмөсөн (үүрд) чөлөөлжээ. >4

FT Бизнес, эдийн засгийн төрөлжсөн сувар Financial Times-ийн нийтлэлүүдийг албан ёсны эрхтэйгээр хүргэж байна.

Эдийн засаг таатай үед нөөц боломжоо нэмэх хэрэгтэй
Татварын орлогын хэмжээнээс илүү тэгш, шударга системтэй байх нь чухал. >5

Baabar: Idiots never realize they are being scoffed and laughed at
ZGM Daily presents the "patriotic speech" delivered by Batbayar Bat-Erdene. >7

ОНЦЛОХ

УЛС ТӨР
Ерөнхийлөгч Х.Баттулга хөгжмийн зохиолч Б.Шаравыг хүлээн авч уулзав.
Нийт хүүхдийн 80 хувьд мөнгөн тэтгэмж олгохыг Төсвийн байнгын хороогоор дэмжлээ.
Ц.Нямдорж, Ч.Хүрэлбаатар нарыг огцруулах үндэслэлгүй гэж Ерөнхий сайд үзжээ.
УХЦ-ийн дөрвөн гишүүнийг өчигдөр парламентаар хэлэлцэв.

ЭДИЙН ЗАСАГ
Улсын хэмжээнд хаврын тариалалт 41 хувьтай буйг салбарын яам мэдээллээ.
55 хувьцаат компанийн ТУЗ-ийн бүрэн эрхийг Санхүүгийн зохицуулах хороо цуцаллаа.
Шивээхүрэн боомтоор өдөрт 750-850 нүүрс тээврийн автомашин нэвтэрч байна.
БНХАУ-ын зах зээлд нүүрсний ханш өсөх төлөвтэй гэж BI таамаглажээ.
ТОР 20 индекс 0.08 хувиар өсөж, 19,741 нэгжид хүрэв



НИЙГЭМ
Элэг шилжүүлэн суулгах хагалгаанд орсон дөрвөн настай Ц.Энх-Номин эмнэлгээс гарлаа.
ТАХ-ын цалингийн асуудлаар Ажлын хэсэг байгуулсан тул эмч нар суултаа зогсоов.
Үндэсний их баяр наадмын нээлт, хаалтыг Н.Наранбаатар найруулна.
НЗДТГ-аас ирэх бямба гарагт "Гуйе! Түүе!" бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулна.

ДЭЛХИЙ
Германы канцлер Меркель БНХАУ-д хоёр өдрийн хугацаатай айлчилж байна.
Вашингтон ОХУ-ын эсрэг илүү хатуу хориг тавихыг Европын холбооноос шаардлаа.
Rusal-ын гүйцэтгэх захирал бусад долоон захирлын хамт үүрэгт ажлаасаа огцорлоо.
Жузеппе Конте Италийн дараагийн Ерөнхий сайдаар тодорлоо.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР
2018.05.25

25° | 13°

БАГА ЗЭРГИЙН БОРООТ

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©


ТООН ҮЗҮҮЛЭЛТЭЭР ТОРТОГТ АМЬДРАЛЫГ ӨНГӨЛЖ ЧАДАХ УУ

#Дундаж цалин сая төгрөг давлаа.
Экспорт нэмэгдэв
#Өрхийн дундаж орлого нэг сая төгрөгт хүрэв
Эдийн засаг 6.1 хувиар өслөө
#Бодит дүн, #тэнцвэртэй мэдээлэл, хаана байна
#Үнэн

Улс орны өнөөгийн нөхцөл байдлыг үнэн, бодитоор тооцон, харуулах учиртай статистикийн байгууллага улс төрийн нам, эрх баригчдын хүссэн хариулт гаргаж, тэдэнд зориулсан аргачлал зохиодог алба болчихоод байна. >3

УЛСТӨР
Гишүүдийн саналаас сонгууль "үнэртээд" эхэллээ
Б.Энхжаргал @enkhjrglzgm

УИХ чуулганаар Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн эцсийн хэлэлцүүлгийг өчигдөр хийлээ.
Жил бүрийн зургадугаар сарын 1 гэхэд дараа оныхоо үндсэн чиглэлийг баталсан байх ёстой тул гишүүд хуулийн хугацаандаа амжих гэж нэлээд шахуу "ажиллав". Засгийн газар хугацааг нь тулгаж оруулж ирснээс, Ажлын хэсэг, Байнгын хороонд төслийг засаж, сайжруулах хугацаа олгоогүй гэсэн шүүмжлэл хэлэлцүүлэг бүр эрт хөндөгдсөн. Хугацааг нь хөөгөөд харвал Сангийн сайд Ч.Хүрэлбаатар дөрөвдүгээр сарын 30-нд төслөө өргөн барьжээ. 25 хоногийн дотор УИХ-ын гишүүд улсын эдийн засгийг өөд нь татах бодлого боловсруулахын оронд сонгогдсон тойрог, ажиллаж байсан салбартаа мөнгө суулгах уралдаан болгоод хувиргачихлаа.
Долоо хоногийн өмнө болсон чуулганы нэгдсэн хуралдаанаар гишүүдийн зарчмын зөрүүтэй санал нэрээр орж ирсэн тойрог, салбарт зориулсан хөрөнгө оруулалтуудын үнийн дүн нэг их наяд төгрөгт хүрч байгааг ЗГХЭГ-ын дарга Г.Занданшатар хэлж байлаа.



ЗГМ: СЭДЭВ
Цахим эриний бүтээл буюу компьютерт донтсон гоонь эрчүүд

З.Цэлмэг @tselmegzgm

Бидний хэдэн найзууд дунд уулзалт алгасалгүй ирдэг нэг шар залуу байдаг юм. Үеийнхэн нь гэр бүл зохиож, ажил, карьерын замаар урагшилж, амьдралаа аваад явдаг. Харин өнөөх шар нөхөр л тогтсон ажил төрөлгүй, зүтгэж байгаа салбар нь тогтворгүй.
Танил тал, найз нөхдөрөө зуучлуулж ажилд ордог ч жил орчим л тэсдэг юм. Ажлаас бусад үед ихэнх цагаа компьютер тоглож өнгөрүүлнэ. Найзууд нь мань хүнийг эхнэр, хүүхэдтэй болохыг ятгадаг ч

FT **Фохсонн-ы салбар Хятадад хамгийн аварга IPO гаргана**

Габриэль Вилдау
Дэлхийн цахим хэрэгслийн гэрээт үйлдвэрлэгчдийн хамгийн аварга нь болох Foxconn Technology компанийн салбар 27 тэрбум юань буюу 4.2 тэрбум ам.долларын хөрөнгө төвлөрүүлэхээр шийдлээ. Уг шийдвэрийн дүнд эх газрын Хятадад хамгийн аварга хэмжээтэй IPO гарах юм.
Үйлдвэрлэл нь Шэньжэньд төвлөрдөг Foxconn буюу Hon Hai Precision Industry нь Apple-ын гол гэрээт үйлдвэрлэгч. Foxconn сүүлийн жилүүдэд Apple iPhone болон персонал компьютерийн нарийн технологитой импортын

АЛТ 1302 0.58%	ЗЭС 6867 1.6%	10-ЧИНГИС БОНД 95.770 0.00%	ХУРАЛДАЙ БОНД 109.36 0.04%	ГЭРЭГЭ БОНД 96.680 0.07%	АМ.ДОЛЛАР 2,411.51	ЮАНЬ 377.59	РУБЛЬ 39.26
-----------------------------	----------------------------	--	---	---------------------------------------	------------------------------	-----------------------	-----------------------

Д.Трамп автомашины импортыг шалгаж эхэллээ

АНУ автомашины импортод шалгалт хийж эхэлснээр дэлхийн худалдааны сөргөлдөөнийг хурцатгаж магадгүй. > 10

Uber хувьцаагаа гаргахын өмнө алдагдлаа танажээ

Uber компани анхдагч зах зээлд нээлттэй хувьцаагаа гаргахын өмнө санхүүгийн байдлаа бэхжүүлэхийг оролдож байна. > 10

Sony-гийн шинэ босс хиймэл оюун ухаанд төвлөрнө

Шинэ захирал К.Ёшида өгөгдөл ба хиймэл оюун ухааныг компанийг аврах стратегийн төвд тавьлаа. > 10



BBM©

Фохсопн-ы салбар Хятадад хамгийн том IPO гаргана

зах зээл сулрах үед эх газрын IPO-г чанд хянадаг. Эрх баригчдын зохицуулалт нь эх газрын арилжаачид “цус сорох” хэмээн нэрийддэг хоёрдагч зах зээлээс хөрөнгө гадагш гаргах үзэгдлийг хязгаарлах зорилготой. Энэ оны нэгдүгээр сарын эцсээр үнэмлэхүй өссөн Shanghai Composite индекс эдүгээ 11 хувиар унаад байна.

“Юникорнууд буюу зах зээлийн үнэлгээ нэг тэрбум ам.доллар давсан компаниудыг листингийг дэмжих, зах зээлийн тогтвортой байдлыг хадгалах хоёрын дунд тэнцвэр бариулах нь зохицуулах байгууллагуудад хүнд дарамт” хэмээн Pinst An Securities компанийн шинжээч Янь Лэй тайлбарлав. Тэрбээр

“Фохсопн-ы загвар нь Хятадын юникорнууд ирээдүйд IPO, CDR гаргахад загвар болж өгнө” хэмээн нэмж өгүүлсэн юм. Эрх баригчдын удирдамжид шинээр гаргах хувьцааны 30 хувийг “стратегийн хөрөнгө оруулагч нар”-г хуваарилахаар заажээ. Журам ёсоор ийм хөрөнгө оруулагч хувьцаагаа нэгээс гурван жил арилжихгүй өөртөө байлгах ёстой. Харин стратегийн бус, байгууллагын хөрөнгө оруулагч (institutional investor) нарт хувьцаагаа 12 сар арилжихгүй байх хугацаа заасан нь ховор үзэгдэл болов. Хятадын хөрөнгө оруулалтын CICC банк уг арилжааны андеррайтер болж байна.



11 ФП 2017 онд 56 тэрбум ам.долларын орлоготой ажилласан нь АНУ-ын Сан Хосед төвтэй, техник хангамж үйлдвэрлэгч CISCO-гийн 48 тэрбум ам.долларын орлогоос их байгаа юм. Тус салбар хувьцааны арилжаанаас төвлөрсөн хөрөнгийг 5G мобайл интернет, автоматжуулсан

үйлдвэрлэлд зарцуулна. Alibaba, Baidu зэрэг хятад аваргууд Нью-Йоркийн биржид бүртгүүлснээс хойш Бээжингийн бодлого тодорхойлогчид технологийн тэргүүлэх группүүдийг эх газрын хөрөнгийн зах зээлд ахиу нэвтрүүлэх арга эрэлхийлж байна. БНХАУ-ын үнэт цаасны зо-

хицуулах хороо энэ оны эхээр Хятадын хадгаламжийн бичиг (CDR - China Depository Receipt) олгох шинэ зохицуулалтын удирдамж танилцуулсан. CDR нь гадаадынхантай хамтарсан группүүдээс АНУ-д хийх арилжааг зохицуулдаг Америкийн хадгаламжийн бичгийн (ADR - American Depository

Receipt) хятад хувилбар болох ёстой. CDR нь гадаадын биржид бүртгэлтэй эсвэл А ангиллын бүртгэлд ердийн нөхцөлд бүртгүүлэх боломжгүй группүүд эх газрын Хятадын биржид бүртгүүлэх боломж олгоно. Хятадын үнэт цаасны зохицуулах байгууллага ялангуяа

Худалдааны нөхцөл иений ханшийг чангаруулав



Эдвард Уайт Геополитикийн нөхцөл муудсанаас хөрөнгө оруулагчид эрсдэлгүй бүс нутгийг илүүд үзэх болсонтой уялдан япон валютын ханш пүрэв гарагт сайжирлаа. Геополитикийн бүрхэг нөхцөлд швейцар франктай адил бас нэг найдвартай валют болдог иений ханш Ази-Номхон далайн бүсийн өглөөний арилжаагаар 0.5 хувиар сайжирсан нь тавдугаар сарын 14-нөөс хойш тохиолдож буй үнэмлэхүй өсөлт юм. “Ногоон”-ыг валютын сагсан дахь бусад мөнгөтэй харьцуулдаг хэмжүүр-ам.долларын индекс мөн хугацаанд дөнгөж 0.1 хувиар суларсан нь иений өсөлт нэгдсэн улсын валют ханшаас төдийлэн шалтгаалаагүйг харуулав. АНУ, БНХАУ, Умард Солонгос зэрэг улсын харилцааг муутгасан хэд хэдэн үйл явдал болсны дараа иений ханш өсөв. АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп, БНАСАУ-ын удирдагч Ким Жон Ун нар зургадугаар

сарын 12-нд уулзахаар товлосон дээд хэмжээний уулзалт болох эсэх нь эргэлзээтэйг Умард Солонгосын мэдээллийн төв агентлаг пүрэв гарагт анхааруулсан. АНУ-д лхагва гарагийн орой ноён Трамп худалдааны асуудал хариуцсан албаны хүмүүстэй автомашины импорт үндэсний аюулгүй байдалд халгаатай эсэхийг судлах үүрэг өглөө. Бээжин Өмнөд Хятадын тэнгис дэх арлуудыг цэрэгжүүлсээр байгаатай уялдан АНУ далайн цэргийн томоохон сургуулиалтдаа Хятадыг урьсан урилгаа саяхан хүчингүй болголоо. Бизнесийн эрсдэл тооцох хандлага Ази тивд төдийгүй Европын худалдаанд нөлөөлж Евросын худалдаанд нөлөөлж буйгаас лхагва гарагт япон иен, швейцар франк аль аль нь өссөнийг Wespac-ын шинжээчид онцолсон юм.



BBM©

Пхеньян АНУ-ын “тэнэг” удирдлагыг зад шүүмжиллээ

Брайан Харрис Умард Солонгос АНУ-ын дээд албаныхны “биеэ тоосон, тэнэг анхааруулга”-ын эсрэг сунжирсан урт шүүмж хөврүүлж, ирэх сард АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамптай хийхээр товлосон уулзалтаас гарахаар сүрдүүлээ. “АНУ бидэнтэй уулзалтын танхим, цөмийн сөргөлдөөн хоёрын алин дунд учрах нь тус улсын авир төрх, шийдвэрээс бүрэн хамаарна” хэмээн Умард Солонгосын Гадаад хэргийн орлогч сайд Чой Сонхуй пүрэв гарагт мэдэгдлээ. Сайдын мэдэгдэл АНУ-ын албаны хүмүүс, ялангуяа цөмийн зэвсгээс ангижруулах “Ливи загвар” дэвшүүлэгч, дэд ерөнхийлөгч Майк Пенстэй холбоотой. Цагаан ордон Умард Солонгосын дэглэмийг түлхэн унагаж, удирдагч Ким Жон Уныг хөнөөх гэсэн утгыг “Ливи загвар” гэсэн үгээр битүү илэрхийлэх нь олширсон юм. Умард Солонгостой хийх гэж буй уулзалттай холбогдуулан

ноён Пенс энэ долоо хоногт АНУ-ын мэдээллийн хэрэгсэлд тайлбар өглөө. Тэрбээр “Бид тохиролцож чадахгүй өнгөрвөл үйл явдал Ливи маягийн загвараар төгсөнө... Байж болох бүх хувилбарыг дэвшүүлж дууссаныг Ерөнхийлөгч Трамп бүр эрт ойлгуулсан. Шууд хэлэхэд бид Умард Солонгосын дэглэмийг хүлцэн тэвчихгүй” хэмээн мэдэгджээ. Ливийн удирдагч Муаммар Каддафийг 2011 онд өрнөдийн дэмжлэгтэй босогчид түлхэн унагаж, амь насыг нь хөнөөсөн юм. Каддафи цөмийн хөтөлбөрөө орхиогүйсэн бол эмгэнэлт тавилангаас мултарч чадах байлаа хэмээн Умард Солонгосын албаны хүмүүс хэдэн жилийн өмнө тайлбарласан юм. “Ливи загвар” нь анхны утгаараа цөмийн зэвсгээс татгалзах тохиолдолд хориг арга хэмжээг цуцалж, эдийн засгийн дэмжлэг үзүүлэх гэсэн санаа илэрхийлж байв. “АНУ-ын дэд ерөнхийлөгчийн амнаас ийм биеэ тоосон, тэнэг анхааруулга гарсанд АНУ-тай

харилцах харилцааг хариуцдаг миний бие гайхаж барахгүй байна” хэмээн хатагтай Чой мэдэгдлээ. Ноён Трамп зургадугаар сарын 12-нд Сингапурт ноён Кимтэй уулзах ёстой. Уг уулзалт Умард Солонгосыг цөмийн зэвсгээс ангижруулах явцыг эхлүүлнэ хэмээн АНУ-ын удирдагч найдаж байна. Вашингтоны “ганц тал барьсан” шаардлагаас үүдэн Пхеньян сүүлийн үед хилэнт мэдэгдэл гаргах болсонтой уялдан түүхэн уулзалт болох эсэх нь эргэлзээ төрүүлээ. “АНУ бидний сайхан сэтгэлийг гутаан доромжилж, хууль бус, цадиггүй өдөөн хатгалга өрнүүлсээр байвал уулзалтад оролцох эсэхээ дахин эргэцүүлэх саналыг миний бие манай дээд удирдагчид тавих болно” хэмээн хатагтай Чой анхааруулав. Ноён Трамп ч уулзалт болох эсэхэд эргэлзэж буйгаа илэрхийлсэн юм. Уулзалтад баримтлах талуудын байр суурь гүн зөрчилтэй нь гол бэрхшээл болж байна. Өөрийнх нь “үнэмлэхүй дарамт” л ноён Кимийг ширээний ард суулгахад

хүргэсэн тул АНУ уулзалтын нөхцөлийг тогтоож, үр дүнг нь тодорхойлно хэмээн ноён Трамп үздэг. Харин Умард Солонгос хүсэл сонирхлынхоо дагуу уулзалтад оролцохоор зөвшөөрсөн тул хэлэлцээ цөмийн зэвсэг бүхий эрх тэгш хоёр улсын түвшинд өрнөх ёстой хэмээн мэдэгдсэн. Үүний зэрэгцээ Пхеньян нь цөмийн зэвсгээс ангижрах үнэнхүү хүсэл эрмэлзэлтэйгээ харуулах үүднээс Пунгери дэх цөмийн туршилтын полигоноо пүрэв гарагт устгахаар бэлтгэж байлаа. Мөн түүхэн үйл явдлын гэрч болгохоор хэд хэдэн сэтгүүлч урьсан. Гаднын шинжээч, эрдэмтдийг уг үйл явдалд оролцуулахгүй. Ноён Трампын “хүчин зүтгэлийн ач” хэмээн анх үнэлэгдсэн цөмийн туршилтын полигон устгах ажил эдүгээ шинжээчдийн шүүмжлэлд өртөж эхэллээ. Полигон устгах нь Умардын дэглэмийн цөмийн хөтөлбөрийн цар хүрээг үнэлэх гэрч баримтыг үгүй хийж буй хэрэг хэмээн шинжээчид үзэж байна.




Уул уурхай

Р.Сэддорж: Татвар төлөлтөөрөө бид улсдаа шилдэг тавд тогтмол шалгарч ирлээ

“Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Р.Сэддоржийн ярилцлаа.

–“Тавантолгой” ХК Монгол Улсын TOP 100 аж ахуйн нэгжийн эхний тавд шалгарчээ. 2017 оны ажлын амжилтаасаа хуваалцаач?

–“Тавантолгой” ХК-ийн хувьд 2017 онд 4.1 сая тонн нүүрс олборлон борлуулж, 427.9 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, улс орон нутгийн төсөвт 183.4 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. Татвар төлөлтийн хувьд улсдаа эхний 5-р байранд эрэмблэгдлээ. Нүүрсний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын хувьд 2-р байранд орж байгаа юм. Өнгөрсөн онд компани 141 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд үүний 90 гаруй хувийг хувьцаа эзэмшигчиддээ өнгод ашиг болгон хуваарилалаа. Нэгж хувьцаанд авч үзвэл 2410 төгрөг ногдож байна. Өмнөговь аймгийн хувьд хамгийн том хувьцаа эзэмшигч (51%) болохын хувьд 64.7 тэрбум төгрөгийн ногдол ашиг авсан байгаа. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд компанийн цэвэр ашгаас Өмнөговь аймгийн



нэмэгдүүлж, 427.9 тэрбум төгрөгт хүргэлээ. Цэвэр ашгийн хувьд 86.9 тэрбум төгрөг буюу 2.6 дахин нэмэгдүүлж 141 тэрбум төгрөгт хүрсэн. Нүүрс борлуулалтын хэмжээ нэмэгдэхээс гадна нүүрсний үнийг гурав дахин нэмэгдүүлж өнөөдрийн байдлаар нэг тонн нүүрсийг уурхайн ам нөхцөлөөр 66 ам.доллараар борлуулж байна. 2018 оны хувьд уурхайгаас таван сая тонн нүүрс олборлон борлуулах төлөвлөгөөтэй. Зах зээлийн нөхцөл байдал харьцангуй тогтвортой байна гэж үзэж байгаа.

– Хувьцаат компани болсон 23 жилийн хугацаанд орон нутгийн хөгжилд оруулсан хувь нэмэр хэр байдаг юм бол?



–Хувь нэмрийн тухайд Өмнөговь аймгийн болон, Цогтцэций сумын хөгжлөөс харагдана байх. Өмнөговь аймгийн хувьд улсын төсвөөс санхүүжилт авдаггүй харин татвар төвлөрүүлдэг цөөн аймгуудын нэг. Сүүлийн жилүүдэд бүтээн байгуулалт, хөгжил дэвшлээрээ 21 аймгаа тэргүүлж шалгарсныг санаж байгаа байх. Өнгөрсөн жилүүдийн дунджийг аваад үзэхэд Тавантолгой ХК-ийн зүгээс төлсөн татвар, ногдол ашиг нь аймгийн төсвийн орлого бүрдүүлэлтийн 60-70 хувь байж ирсэн байдаг. Орон нутгийн өмч давамгайлсан, нээлттэй хувьцаат компанийн хувьд засаглалын хамгийн ил тод хариуцлага өндөртэй гэж ойлгож болно. Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй байгаа 200 орчим компаниудиаас хамгийн их ногдол ашиг хуваарилсан компаниар бүртгэгдсэн байдаг. 2009 оны тавдугаар сард нэгж хувьцаа 970 төгрөг байсан. Өнгөрсөн жил тухайн сард 4400 төгрөг болсон харин, өнөөдрийн хувьд 10000 төгрөгийн ханштай худалдаалагдаж байгаа. Энэ тоо юу харуулж байна вэ гээд жишээгээр тайлбарлахад 2009 онд манай хувьцаанд нэг сая

төгрөгөөр хөрөнгө оруулсан хүний хувьцаа өнөөдрийн байдлаар 10 сая төгрөгийн үнэлгээтэй болсон байгаа юм.

–Хувьцаат компани ашигтай ажиллаж, ногдол ашиг тараана гэдэг тухайн компанийн чансаа, үнэ цэнийг илтгэж буй хэрэг л дээ.

–Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй байгаа 210 компанийн хувьд өнөөдрийн байдлаар 1-р зэрэглэлийн компанийн ангилалд хамаарч байгаа. Энэ ангилал нь компанийн үнэлэмж, ногдол ашиг тараалт, засаглалын зөв хэлбэрээр явж байгаа эсэх зэрэг олон шалгуураар ангилж тодорхойлогддог. Нэгж хувьцаа эзэмшигчид өнгод ашиг ирдэггүй, хэн нэгний шахааны бизнес нутагшдаггүй, хараа хяналт маш сайн, шалгарсан загвар болохыг бидний ажлын үр дүн харуулж байна. Ер нь манай улсын орон нутаг дахь компаниуд ийм бүтцийг жишиг болгоосой гэж боддог. Бид зах зээлийн үнэлгээний хувьд нийт компаниудын тэргүүлэх эгнээнд явж байна. Өнгөрсөн 52 долоо хоногийн үзүүлэлтийг авч үзэхэд хувьцааны үнэ 850-13310 төгрөг болсон. Энэ нь тус хугацаанд нэгж хувьцааны үнэ 14.5 дахин нэмэгдсэн гэсэн үзүүлэлт гарч ирж байгаа юм. Жишээ болгоод сонирхуулахад анх хувьцаат компани болж байхад уурхайд маань ажиллаж байсан ажилчдаас хувьцаа эзэмшиж өнөөдрийг хүртэл ногдол ашгаа аваад явж байгаа манай ахмад уурхайчин байна. Сая гарсан шийдвэрийн дагуу жилдээ 600 орчим сая төгрөгийг ногдол ашгаар аваад явж байна шүү дээ.

АШГИЙН ХЭМЖЭЭ		ТАТВАР	
Ранк	Нэр	Ранк	Нэр
1	Эрдэнэс -Таван толгой ХК	1	Эрдэнэт Үйлдвэр ХХК
2	Энержи Ресурс ХХК	2	Оюу Толгой ХХК
3	Эрдэнэт Үйлдвэр ХХК	3	Эрдэнэс -Таван толгой ХК
4	Монголын Алт (Мак) ХХК	4	АПУ ХК
5	ТАВАНТОЛГОЙ ХУВЬЦААТ КОМПАНИ	5	ТАВАНТОЛГОЙ ХУВЬЦААТ КОМПАНИ
6	Хаан банк	6	Тийсс Монгол ХХК
7	Тийсс Монгол ХХК	7	Монголын Алт (Мак) ХХК
8	Ти Ти Жи Ви Си Өү ХХК	8	НИК ХХК
9	Цайрт Минерил ХХК	9	Цайрт Минерил ХХК
10	Саусгоби Сэндс ХХК	10	Магнай Трейд ХХК



төсөвт зөвхөн ногдол ашгаар 215 тэрбум төгрөг төвлөрүүлсэн.

–Өмнөговь аймагт хэдэн оноос хойш ногдол ашиг хуваарилаж эхэлсэн бэ?

–Эхлээд компанийн түүхийн талаар товчхон мэдээлэл өгье. Манай компанийн

хувьд Тавантолгойн бүлэг орд дээр MV-000287/A тусгай зөвшөөрлийн талбайд нүүрс олборлолт, борлуулалтын үйл ажиллагаа явуулж ирлээ. 1966 онд ордыг анхлан эзэмшиж өнөөдрийг хүртэл 52 дахь жилдээ үйл ажиллагаагаа

тасралтгүй явуулж байна. Компанийн өмчлөлийн хувьд маш онцлогтой. Өмнөговь аймаг 51 хувийг эзэмшдэг бол үлдсэн 49 хувийг нь Монголын хөрөнгийн бирж дээр худалдаалж, Монгол Улсын болон гадаадын улс орны иргэд

ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:

АПУ ХК <p>Өдөр ↑ 0.25% Сар ↑ Жил ↑</p>	ГОВЬ ХК <p>Өдөр ↑ 1.48% Сар ↑ Жил ↑</p>	ТАВАН ТОЛГОЙ ХК <p>Өдөр ↑ 1.90% Сар ↑ Жил ↑</p>	СҮҮ ХК <p>Өдөр ↓ 6.61% Сар ↓ Жил ↑</p>				
DOW JONES 0.21%	S&P 500 0.32%	FTSE 100 0.015%	NIKKEI 225 1.1%	TOPIX 0.33%	SHANGHAI COMPOSITE 0.45%	HANG SENG 1.82%	KOSPI 0.08%